

«МОНГОЛ БРИТАННИКА»  
МАДАГ ИХТЭЙ БОЛЖЭЭ

Л.Норовсүрэн\*

\* МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

**Түлхүүр үг:** хэвлэн нийтлэгч, Нобелийн шагнал, тулгуур бүтээл, залруулга, ном эрдэм, нийтлэл, төрийг засах, сэтгүүл зүй, гэгээрэл, судар бичиг

«Британийн нэвтэрхий толь» (Encyclopaedia Britannica) хэмээх бүтээлийг анх Шотландын соён гэгээрүүлэгч Эндрю Белл, номын худалдаачин, хэвлэн нийтлэгч Колин Макфаркар нар зохиож, Уильям Смелли редакторлан 1768-1771 оны хооронд нийт гурван ботиор хэвлэн гаргаснаас хойш 240 гаруй жил өнгөрчээ. «Британника» найм дахь хэвлэлээ хүртэл Эдинбургт гарч байгаад 1870 онд «The Times» сонины ивээлд багтаж Лондонд шилжин ирсэн байдаг. Тэр цагаас хойш 9, 10 дугаар нь Их сургуулийн албан бус харьяалалд, 11 дэх хэвлэл нь Кембрижийн хэвлэл болж гарчээ. Уг толийг орчин үед Кембрижийн Их сургуулийн 1500 экспертийн оролцоотойгоор баяжуулан хэвлэж байдаг аж.

Өнгөрсөн хугацаанд «Британника»-г цаасан, цахим, мультимедиа зэрэг олон хэлбэрээр хэвлэж, бүтээх үйлсэд нь Зигмунд Фрейд, Альберт Эйнштейн, Мария Кюри, Генри Форд, Лев Троцкий нар тэргүүтэй 4000 орчим зохиогч

оролцсоны дотор Нобелийн шагналтан хэдэн арав байгаа юм. Хамгийн сүүлд нийтдээ 32 мянган нүүр хуудас бүхий 32 ботиор хэвлэгдэж, 65 мянган өгүүлэл, 24 мянган фото зураг, чимэглэлийг багтаасан «Британника»-ийн цаасан хэвлэл 1400 доллараар зарагддаг байна. Эдгээр баримт нь «Британника» ямар их хүч хөдөлмөрөөр бүтсэн, хэр зэрэг цар хүрээ, үнэ цэнтэй бүтээл болохыг харуулж байгаа юм.

Манай хэсэг оюунлаг сэхээтэн уг толийн монгол хувилбарыг бүтээхээр сэтгэл нийлэн ажилласанд ном эрдмийг дээдэлдэг хэн бүхэн баярлаж талархсан гэдэгт эргэлзэхгүй байна. Гэвч шинэ юм сэдэж, хэрэгтэй тустай юм хийх гэсэн өөдрөг санаанд нь дулдуйдаж, түүний цаана байгаа алдаа эндэгдлийг залруулахгүй байж болохгүй билээ. Тэр тусмаа хүн ардын оюуны тэжээл болох ном хэвлэлийг хуудуутай, ач холбогдол багатай баримт, мэдээллийн “агуулах” болгож, тулгуур бүтээлд орох хэмжээнд хүрээгүй танил тал, ойр тойрныхныхоо намтраар дүүргэснийг залруулахгүй удвал тэрхүү буруу ташаа мэдээлэл олон нийтийн санаанд хоногшин, үнэн биш “үнэн” болж нийгмийн оюун санааг

хордуулах аюултай юм. Зүйрлээд хэлбэл муудсан хоол идээд хордохтой адил.

«Монгол британника»-д байгаа эндэгдлийг **нэгдүгээрт**: баримт мэдээллийг сайтар нягталж шалгаагүйгээс үүдсэн алдаа, **хоёрдугаарт**: түүхт хүмүүс, үйл явдал, баримтыг ач холбогдлоор нь эрэмбэлж сонгоход гарсан алдаа, **гуравдугаарт**: тохиолдлын шинжтэй буюу гарын дорх материалаар номоо бүрдүүлсэн сул тал гэж гурав ангилж үзмээр байна. Эхлээд эхний ангилалд хамаарах, тэр тусмаа өөрт ойр дөт байдаг зарим нэгэн баримт хэрхэн ташаарсныг дурдъя.

1911 онд Монгол улсад Үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн ялж, 200 гаруй жил ноёрхсон Манжийн дарлалаас чөлөөлөгдсөн нь ХХ зууны Монголын амьдралд тохиолдсон гарамгай үйл явдлуудын нэг мөн билээ. Энэ түүхэн үйл явдалд талархаж, түүнийг төгөлдөржүүлэхэд эр чадал, эрдэм мэдлэгээ зориулсан монгол туургатны шилдэг хөвгүүдийн нэг нь буриад Жамсрангийн Цэвээн байв. Тэрээр Монголын тусгаар тогтнолыг хамгаалахад туслах, ард түмнийг олон үеийн оюуны хоцрогдлоос ангижруулах зорилгоор 1913 онд «Шинэ толь хэмээх бичиг» гэдэг сонин гаргасан нь Монголын сэтгүүл зүйн тулгын чулууг тулсан хэрэг байлаа.

Ж.Цэвээн өөрийн эрхлэн гаргаж байсан сониноор дамжуулан эхний үед Богд хаант Монгол улсын авч хэрэгжүүлж байсан дэвшилттэй үйлсийг хөхиүлэн дэмжиж, улс төрийг засах арга ухааныг санал болгож байсан бол, аажимдаа Монголын ихэс дээдэс улс үндсээ бадруулъя гэхээсээ илүү хувийн эрх ашиг, нэр төр, албан тушаалын хойноос хөөцөлдөх болсныг шүүмжилж эхэлсэн байдаг. Үүнд нь шашин, төрийн

мяндаг тушаалтнууд дургүйцэж, сониныг хаалгах саналыг Богд хаанд удаа дараа өргөн мэдүүлж байсан үед Ж.Цэвээнийг Хиагтад болсон Гурван улсын хэлэлцээрт хэлмэрчлүүлэх нэрийдлээр явуулсан байдаг. Энэ нь үнэн чанартаа “барсыг уулнаас нь салгасан”-тай адил хэрэг болсон юм.

**Ж** Цэвээн Гурван улсын хэлэлцээрээс эргэж ирээд «Шинэ толь хэмээх бичиг» сониноо «Нийслэл хүрээний сонин бичиг» нэрээр үргэлжлүүлэн гаргаж, нийтлэлийнх нь сэдэв агуулгыг өргөтгөн, «Шинэ толь хэмээх бичиг»-ийг бодвол мэдээллийн шинж давамгайлсан сонин болгосон юм. Энэ сонины анхны дугаар 1915 оны 9 дүгээр сарын 1-нд гарсан билээ. Гэтэл «Монгол британника»-ын зохиогчид уг сониныг «1915 оны 6 дугаар сарын 1-нээс эхлэн гарсан» гэж илэрхий ташаарчээ.

Толь зохиогчид бас их зохиолч Д.Нацагдоржийн гэргий «Дамдины Пагмадулам 1924-1925 онд МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Бүсгүйчүүдийг боловсруулах тасгийн анхны эрхлэгчээр ажиллаж байсан» гэж тов тодорхой бичжээ. Түүхэн үнэнийг хэлбэл 1921 онд Москва хотод Олон улсын эмэгтэйчүүдийн их хурал болж Монголоос Ж.Цэвээн, С.Бадамжав, Хорол нар оролцож ирсний дараа С.Бадамжав олон улсын эмэгтэйчүүдийг нэгтгэсэн байгууллага байдаг, түүнд улс орнуудын эмэгтэйчүүдийн байгууллага гишүүнээр элсдэг тухай танилцуулсны үндсэн дээр Төв Хорооны дэргэд 1922 онд Бүсгүйчүүдийн тасаг байгуулагдсан байдаг. Тус тасгийн анхны эрхлэгчээр Хобоно Ренчино (Элбэгдорж-Ренчиногийн эхнэр) томилогдож байсан архивийн баримт бий. Нөгөө талаар Д.Пагма-

дулам анхны эрхлэгч юм бол 1924-1925 онд Бүсгүйчүүдийн тасгийг эрхэлсэн баймааргүй байна. Д.Сүхбаатарын гэргий, Бүсгүйчүүдийн тасгийн дарга Янжмаа 1925 оны хавар болсон МАХН-ын 4 жилийн ойн баярын хурлын тэргүүлэгчээр сонгогдож, «Ардын эрх» сонины мөн оны 3 дугаар сарын 6-ны өдрийн дугаарт Бүсгүйчүүдийн тасгийн даргын хувиар Монголын эмэгтэйчүүдийн өмнө тавигдаж байсан зорилтын талаар «Хичээн оролдоцгоомуй»<sup>1</sup> гэсэн гарчигтай өгүүлэл нийтлүүлж байсан баримт байна. Түүнчилэн 1924 оны 9 дүгээр сарын 14-нд эхэлсэн Монголын Залуучуудын Эвлэлийн III Их хуралд «Бүсгүйчүүдийн эвлэл («Ардын эрх» сонинд “эвлэл” гэж бичсэн — Л.Н)-ийг төлөөлж хүүхэн Бадамринчен үг хэвлэв»<sup>2</sup> гэж бичжээ. Энэ бүхнээс үзвэл 1924-1925 онд Д.Пагмадулам бүсгүйчүүдийн байгууллагад хамааралгүй байсан нь тодорхой байна.

«Монгол британника»-ын мадагтай баримтууд үүгээр дууссангүй. Зохиогчид «Эрдэнэбатхаан 1913-1914 онд “Шинэ толь” сониныг эрхлэн гаргаж, “Нийслэл хүрээний сонин бичиг”-т соён гэгээрүүлэх нийтлэл бичиж байсан»<sup>3</sup> гэж чилмэрээ ч үгүй туусан байх юм. «“Шинэ толь”-ийг эрхлэн гаргасан» гэдэг нь энэ ташаа баримтын даан ч дэндсэн гэмээр “оргил” нь болжээ. «Шинэ толь хэмээх бичиг» сонин 1913 онд гарч, Ж.Цэвээн эрхэлж байсныг боловсролтой хүн бүхэн мэднэ. Тус сонин гарснаар Монголын сэтгүүл зүйн

түүх эхэлсэн, эрхлэгч Ж.Цэвээнийг Монголын сэтгүүл зүйг үндэслэгч гэж нийтээр хүлээн зөвшөөрсөн, хоёр жилийн өмнө Монголд үндэсний сэтгүүл зүй үүссэний 100 жилийн ойг тэмдэглэснийг мэдэхгүй баймааргүйсэн.

Толь зохиогчид Эрдэнэбатхааныг 1890 онд төрсөн гэжээ. Зарим эх сурвалжид 1888 онд Эрхүү мужийн Тарас Балогон хошуунд төрсөн ч гэдэг. Аль нь ч байлаа гэсэн дөнгөж хорь гарч яваа, их л сайндаа Эрхүүгийн багшийн сургууль төгсөөд байсан шавилхан залуу тэгтлээ их соён гэгээрүүлэх нийтлэл бичиж байсан гэхэд эргэлзээ төрнө. Дашрамд тэмдэглэхэд «Шинэ толь хэмээх бичиг»-ийн соён гэгээрүүлэх нийтлэлүүд нь эрхлэгч Ж.Цэвээний Буяндалай (төвд

нэр нь дооромбо Гэлэгжамц)-тай хамтран бичсэн «Орчлонт ертөнцийн байдлыг үзүүлсэн дэвтэр» гэдэг зохиолын хэсгүүд байсан юм. Уг номын хэсэг Өвөр Монголын тогтмол хэвлэлд ч цувралаар нийтлэгдэж байсныг судлаачид тэмдэглэсэн байдаг. Тухайлбал залуу судлаач, доктор Н.Ариунзаяа «Эрдэмтэн-сэтгүүлч Ж.Цэвээний нэгэн бүтээлийн тухай» гэдэг өгүүлэлдээ «Уг ном зөвхөн Ар Монголд төдийгүй өвөрлөгчдийн дунд өргөн тархаж, сургууль соёлын газарт үзэж судлан, сонин хэвлэлд ч хэсэглэн нийтэлж байсан бололтой байна. Түүний наад захын жишээнд 1918 оны үед Хятадын Зүүн хойд мужид гарч байсан “Мүгдэнгийн монгол сэтгүүл”-д уг

«

**«Монгол Британника»-д байгаа  
эндэгдлийг 1-рт: баримт  
мэдээллийг сайтар нягталж  
шалгаагүйгээс үүдсэн алдаа, 2-рт:  
түүхт хүмүүс, үйл явдал,  
баримтыг ач холбогдлоор нь  
эрэмбэлж сонгоход гарсан алдаа,  
3-рт: тохиолдлын шинжтэй буюу  
гарын дорх материалаар номоо  
бүрдүүлсэн сул тал гэж гурав  
ангилж үзмээр байна**

»

номын хэсгээс нийтэлснийг дурдаж болно. Хамгийн сонирхолтой нь хэсэглэн авсан тэр нийтлэлд Ж.Цэвээний эрхлэн гаргаж байсан “Шинэ толь хэмээх бичиг” сонины уриа болох “Түмэн зүйлийг бадруулж, элдэв ухааныг нэвтрүүлмой” гэдгийн “Элдэв ухааныг нэвтрүүлмой” гэснийг бараг тэр янзаар нь гулсуулан авч “Элдэв ухааныг бадруулан нэвтрүүлэх нь” гэсэн гарчиг өгч нийтэлсэн явдал мөн<sup>4</sup> гэжээ.

**Э**рдэнэбатхаан «Шинэ толь хэмээх бичиг»-т биш юмаа гэхэд гэгээрүүлэх чиглэлийн нийтлэл бичиж байсан цаг үе ядахдаа 1921 оноос эхэлсэн байх бололцоотой байна. Учир нь тэрээр 1921-1924 онд Ардын түр засгийн газрын нарийн бичгийн дарга, Гадаад яаманд орчуулагч, сургуулийн хэрэг эрхэлсэн түшмэл, Оюутны сургуульд багш, Судар бичгийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, Дотоод явдлын яамны сургуулийн хэлтсийн эрхлэгч зэрэг ажил хийж байгаад 1924 оны 11 дүгээр сараас Гэгээрлийн яамны сайд болсон байдаг. Энэ үед эрхэлсэн ажил үүргийн шаардлагаар гэгээрүүлэх, зохион байгуулах шинжтэй нийтлэл бичиж, хэд хэдэн ном зохиол туурвисныг түүхийн шарласан хуудсууд гэрчилнэ.

Эрдэнэбатхаан 1926 онд Германд «Монгол орны газрын зургийн атлас», «Ази тив» зэрэг хэд хэдэн ном хэвлүүлж, мөн оны 8 дугаар сард Италийн Сорренто хотод их зохиолч М.Горькийтой уулзаж Монголын хэвлэн нийтлэх ажил, уран зохиолын орчуулгад баримтлах зарчмын талаар санал солилцож зөвлөгөө авч байжээ. Буриадын нэрт эрдэмтэн Г.Цыбиковын дурсан тэмдэглэснээр 1927 оны байдлаар Улаанбаатар хотод зургаан

хэвлэлийн газар байсны дотор Эрдэнэбатхааны гадаадад явж байхдаа олж ирсэн хэвлэх машин хамгийн боловсронгуйд тооцогддог байсан аж. Тэрээр «Бүх дэлхийн түүх», «Азийн судлал», «Дэлхийн газар зүй», «Пионер багачуудад мөрдөх дэвтэр» зэрэг сурах бичиг, зөвлөгөө, гарын авлага, нийтлэлийн ном туурвин хэвлүүлсэн соён гэгээрүүлэгч сэхээтэн байсан нь зайлбаргүй боловч, «Шинэ толь хэмээх бичиг»-ийг эрхэлж, «Нийслэл хүрээний сонин бичиг»-т гэгээрүүлэх нийтлэл бичиж байсан гэдэг нь ор үндэсгүй алдаа болжээ.

«Монгол британника»-ын зохиогчид «Залуучуудын үнэн» сонин 1924 оноос гарч эхэлсэн гэжээ. Энэ нь 1924 оны 3 дугаар сарын 26-наас эхлэн таван сар хэртэй гараад тухайн үеийн «Ардын эрх» сонинтой нийлсэн «Манай үнэн» гэдэг сониныг хэлсэн бололтой. Яг «Залуучуудын үнэн» гэдэг нэртэй сонин 1930 онд гарсан юм. Аль аль нь залуучуудын байгууллагын сонин мөн боловч барьж, үзэхэд тэс ондоо нэртэй, өөр өөр өнгө зүстэй сонинууд юм. Нэг айлын хоёр хүүхдийн дүүгийнх нь нэрийг ахад нь өгч, ахынх нь нэрийг баллуурдаж болохгүй биз дээ. Тиймээс залуучуудын сонин анх 1924 онд «Манай зам» гэдэг нэрээр гарч, 1930 оноос «Залуучуудын үнэн» гэж нэрээ өөрчилжээ гэвэл маргаангүй болох байжээ.

Зохиогчид бас МОНЦАМЭ агентлагийн эх суурь 1921 оны 7 дугаар сарын 19-нд «МОНТА» гэдэг нэрээр тавигдсан гэж зөв зүйтэй тэмдэглэсэн атлаа, тэр нэрээрээ тасралтгүй 1957 он хүртэл оршин тогтносон мэтээр бичжээ. «МОНТА»-г 1938 онд татан буулгаж, үүргийг нь «Үнэн» сонинд хариуцуулах болсноор үндэсний мэдээллийн агентлаг хорь шахам жил завсарласныг

эрхэм зохиогчид мэддэггүй юм уу, эсвэл тэр үнэнийг хэлэхээс зайлсхийв үү. Гүйлгээд харах зуур энэ мэт алдаатай зүйл захаас аван тааралдаж байна. Ганцхан салбарын хэдхэн сонин хэвлэлийн тухай товч дурдахдаа ингэж алдаж байгаа улс өөр бусад салбарын мэдээлэлд хэчнээн олон алдаа гаргасан бол доо гэх бодол өөрийн эрхгүй төрснийг нуух юун.

Тольд намтар нь бичигдсэн Бадамын Лхамсүрэн гэдэг хүн 1923 онд төрсөн атлаа ШУА-ийг үүсгэн байгуулалцсан болоод явчихлаа. Хожим нэрийг нь “Шинжлэх ухааны академи” гэж өөрчилсөн уг байгууллагын эх суурь 1922 онд Засгийн газрын тогтоол, эрдэмтэн Ж.Цэвээн, О.Жамьян нарын зэрэг хүмүүсийн идэвхтэй оролцоотойгоор тавигдсан билээ. Тэгэхээр Б.Лхамсүрэн төрөхөөсөө нэг жилийн өмнө Судар бичгийн хүрээлэнг үүсгэн байгуулалцсан болж таарах нь. Үүнийг бичигч хэрэв “академи” нэртэй болох үеийн явдлыг ярьж байгаа бол тэр нь “үүсгэн байгуулалцсан” биш, үйл ажиллагаанд нь “оролцсон” гэвэл үнэнд ойртох байжээ. Энэ мэт ноцтой алдааны зэрэгцээ утга зохиолын шүүмжлэгч Д.Галбаатарыг «1976 онд УБДС төгссөн болгож», яруу найрагч Ц.Хуланг «УБДС-ийг төгссөн» мэтээр ташаарсан зэрэг жижиг сажиг алдаануудыг энд дурдсангүй.

«Монгол британника» гэгчид гарсан нэг бүлэг ноцтой алдаа нь баримт мэдээллийг эрэмблэлгүй энд тэндээс ойчин цойчин авсан явдал мөн. Нэвтэрхий толь мэт аливаа итгэмжит, тулгуур бүтээлүүдэд хамгийн түрүүнд анхаарах ёстой зүйл бол баримт, мэдээллийн сонголт байдаг. Нэг үгээр хэлбэл орох ёстойг орхигдуулж, орох ёсгүйг оруулахаас сэрэмжилнэ гэсэн үг. Ингэхийн тулд түүхэн хүн, үйл явдлыг

бүрэн харж, матрицын аргаар эрэмбэлж оруулах ёстой байдаг. Зохиогчид энэ тухай огт бодоогүй бололтой. Жишээ нь хөдөлмөрийн баатар, малчин Т.Нугыг тольд оруулсан хэрнээ алдарт хоньчин С.Цогтгэрэл, С. Содномбалжир, тэмээчин Л.Хүрээт, Б. Үрчгэр гэх зэрэг Т.Нугатай нэг эрэмбийн, зарим нь бүр илүү гавьяатай олон баатруудыг огт дурссангүй. Түүнтэй адил хөдөлмөрийн баатар нэгдлийн дарга нараас Ү.Аварзэдийг оруулсан хэрнээ мөн л түүний адил Ч.Чулуун, О.Ядамхүү, С.Адьяшаажав, Б.Лувсан гэх зэрэг олон хүнийг орхигдуулжээ. Ийм алдааг бараг бүх салбарын мэдээллээс олж болно. Жишээ нь Р.Нарангэрэл гэдэг хүн УИХ-ын гишүүн байсан, иргэний нийгмийн зүтгэлтэн гэдэг үндэслэлээр толь бичигт орж гэж бодъё. Тэгвэл УИХ-ын 12 удаагийн сонгуулиар сонгогдсон хэдэн зуун гишүүн, иргэний нийгмийн байгууллагын нэрд гарсан зүтгэлтнүүд хаачив? гэсэн асуулт гарч ирнэ. Уг нь ийм хүмүүсийг оруулбал бүгдийг оруулаад, үгүй бол хэнийг нь ч оруулахгүй байх нь зүйд нийцэх юм.

**Б.** Намбар гэдэг хүнийг рашаан судлаач, эмч байсных нь төлөө намтар түүхийг нь бичжээ. Тэр хүнийг ийм суурь бүтээлд орох ёсгүй хүн гэж би хэлэхгүй. Гэтэл хөдөлмөр зүтгэлээрээ цолгорон гарч, бүр “Ардын эмч” хэмээх өндөр алдар хүндэтгэл хүлээсэн П.Шижээ, А.Нота, Д.Дэлэг гэх мэт хүмүүс ор сураггүй орхигджээ. Түүнчилэн жүжигчин, зураач, сэтгүүлч, эрдэмтэн гэх мэт соёл урлаг, шинжлэх ухааны салбарынхны сонголт гэж авах юм алга. Шуудхан хэлэхэд ойр тойрныхоо танил хүмүүсийн хүрээнд л сонголтоо хийсэн аж.

Тольд Хятадын эртний болоод ойрх үеийн улс төр, цэргийн зүтгэлтнүүд

олноороо оржээ. Тэдгээрийн заримынх нь намтар Монголын түүхэнд холбогдож байсан тухай ганц өгүүлбэр ч алга. Тэгэхээр энэ чинь монгол британник уу, хятад британник уу? гэж асуухаас өөр арга алга. VIII зууны үед Тан улсын зургаа дахь эзэн хаан байсан Ли Лунзи, 454 онд төрж 22 насалсан, хаан ширээнд таван жил суусан Сянь Вэньди, 1864 онд төрсөн Хятадын цэрэг, улс төрийн зүтгэлтэн Ли Юаньхун зэрэг олон хүний намтрыг ямар үндэслэлээр монгол тольд оруулсан нь тодорхойгүй байна. Бодвол нэг хятад судлаач юм уу, эсвэл хятад хэлтэй нөхөрт Монголттой холбоотой хятадын түүхэн хүмүүсийн товч намтар бичихийг даалгаад орхитол нөгөөх нь тааралдсан болгоныг хамаж аваад ирсэн бололтой юм. Нөгөө талаар Монголын түүхэнд зайлшгүй холбогдох дэлхийн олон орны улс төрийн зүтгэлтэн, эрдэмтэн мэргэдийг бүрэн оруулаагүй атлаа хятадуудыг бөөн бөөнөөр нь оруулсан нь сэжигтэй мэт санагдана.

«Монгол британника»-ын гурав дахь бүлэг алдаа нь тохиолдлын шинжтэй баримт, үйл явдлын мэдээгээр дүүрсэнд оршино. Ёстой л нөгөө “тоон дотор үсэг цохиж явна” гэдэг шиг нөхдүүд тольд орсон байх юм. Захаас нь заримыг эшлэе.

2008 онд МУИС-ийг төгссөн Д.Хүрэлхүү тулгуур бүтээлд намтраа бичүүлэх гавьяатай юм байж гэж бодъё. Тэгвэл насаараа урлагт зүтгэсэн ахмадууд тойргийн гадна үлдэх хамаагүй юу? 1978 онд төрж, 2002 онд ТИС-ийг төгссөн Д.Түмэн-Өлзий нийтлэлч, блогчин гэнэ. Тоймтой юу бүтээсэн хүн юм бол гээд сонирхтол нэг түүвэр хэвлүүлсэн гэж байна. Тэгвэл хорь гуч, бүр дөч тавин боть ном биччихсэн зохиолч, эрдэмтэд шүүрэнд өртөөгүй нь ямар учиртай вэ?

А.Ундраа 1973 онд төрж, 1994 онд МУИС-ийг төгсөж цөмийн физикч болсныхоо төлөө намтар түүхээ сийлүүлж болдог юм байж. Гэтэл ухамсарт амьдралаа энэ салбарт зориулсан “акул”-ууд нь ор сураггүй байдаг. Д.Мөнгөндалай гэдэг хүн 1999 оноос хэвлэл мэдээлэлд ажилласан юм байна. Арваад жил өнгөрчээ. Гэтэл аль тэртээх арван хэдэн онд хилийн чанадад сэтгүүлчээр ажиллаж байсан Б.Намсрай, Д.Намсрай, Д.Далхжав, Монголын анхны сониныг үүсгэн байгуулалцсан сэтгүүлч Д.Бадрахбаатар нараас эхлээд дөч, тавин жил хэвлэл мэдээллийн салбарт зүтгэж явсан, одоо ч зүтгэж байгаа ахмадууд “хог дээр” хаягдсан байх жишээтэй. 1987 онд төрж, 2008 онд МУИС-ийг төгссөн Д.Хүрэлхүү гэдэг хүнийг «Дэлхийн шинэ атлас» гэдэг номыг редакторласны төлөө “толь зүйч” хэмээн цолложээ. Ном эрдмийн мөр хөөгөөд таван жил ч болоогүй хүүхдийг ингэж хөөргөх нь нэг талаар залуу хүнийг эвдэх аюултай, нөгөө талаар цаана нь байгаа үхсэн, амьд олон зүтгэлтнийг түүхээс арчиж, алагчилсан нүгэл болжээ.

**Т**үүнчилэн 2007 онд МУИС-ийг төгсөөд «Миний мэдэх хөл бөмбөг» ном гаргасан сэтгүүлч Б.Батзаяа, «Пиав уух зуур» гэдэг ганц түүвэр хэвлүүлсэн Д.Билгүүн гэх мэт бүтээж туурвих замынхаа эхний гишгүүр дээр хөл тавьж байгаа залуусыг ийм том суурь, тулгуур бүтээлийн хойморт залсан нь ихээхэн хуумгай явдал болжээ. Бүр үзвэрийн газрын үүдэн дээр хүн хутгалаад алж байсан эрүүгийн хүнд гэмт хэрэгтэн “Чонон Борис” гэгч хүртэл цохиж яваа нь ямар учиртай юм бол! Арай хүн алахыг ид бах болгох гээгүй баймаар.

Монголоос өөр газарт ийм толь бичиг байдаг болов уу? Гадна дотнын

аливаа толь бичиг, лавлагааны ном зохиолыг харж байхад жинхэнэ шалгарсан эрхмүүд л багтахаас бус найз нөхөд, нэр төрд дурлагсад, нам дагаж, хүн дагаж гүйгсэд зэрэг “будааны” хүүхдүүдэд багтаж шингэх зай байдаггүй юм билээ. Ингэж хэлэхдээ би номд орсон хүмүүсийг буруутгах гэсэнгүй, шилэн сонгож шалгарсан үйл явдал, хүмүүсийг номын хойморт байрыг нь эзлүүлсэнгүй л гэж зохиогчдод сануулах гэсэн хэрэг. Уг бүтээлд хүмүүсийг оруулах ёстой гэж үзсэн л бол тэдгээр нь улс орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө материаллаг болон оюуны салбарт бие хайргүй зүтгэж түүхэн гавьяа байгуулж, тод мөр үлдээсэн хүмүүс байх учиртай. Ингэж чадаагүйд л өчүүхэн хүн сэтгэл чилж, бяцхан шүүмж үүнийг тэрлэв.

**Э**цэст хэлэхэд нэгэнт эх суурийг нь тавьчихсан энэ бүтээлийг хэн нэгэн, хэзээ нэг цагт сэлбэж баяжуулаад дахин хэвлүүлнэ гэдэгт эргэлзэхгүй байна. Тэр цагт энэ мэт эндүү ташааг залруулаасай хэмээн горилж сууя.

#### Ишлэл

- <sup>1</sup> «Ардын эрх» сонин. 1925. № 49.
- <sup>2</sup> «Ардын эрх» сонин. 1924. № 16 (Хавсралт).
- <sup>3</sup> 2012. Британника Монгол. УБ., 750 дахь тал.

<sup>4</sup> *Ариунзаяа Н.* 2015. Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн зарим асуудал. УБ., 41 дэх тал.

#### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2012. Британника Монгол. УБ., 750 дахь тал
2. «Ардын эрх» сонин. 1924. № 16 (Хавсралт).
3. «Ардын эрх» сонин. 1925. № 49.
4. *Ариунзаяа Н.* 2015. Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн зарим асуудал. УБ.
5. *Дэлэг Г.* 1965. Монгол тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ.
6. *Норовсүрэн Л.* 1999. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. (Тэргүүн дэвтэр). УБ.
7. *Норовсүрэн Л.* 2004. Монголын нийтлэл. (Тэргүүн боть). УБ.

#### Резюме

В рецензии на энциклопедию «Монгольская Британника» предпринята попытка исправить фактологические и другие ошибки и недочёты, допущенные авторским коллективом. Опираясь на конкретные примеры, автор рецензии классифицировал ошибки следующим образом: ошибки, связанные с фактами и информацией; неправильный, однобокий выбор людей, чьи биографии попали в энциклопедию, наряду с игнорированием тех, кто был достоин попасть в этот список и наполнение энциклопедии незначительными, случайными персонами, близкими к авторскому коллективу. Кроме того, автор рецензии критически относится к тому, что энциклопедия наполнена биографиями людей, которые не имеют ни малейшего отношения к истории Монголии.